



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 18 өдөр

Дугаар 0/Н09

Алтай хот

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.5 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн “Журам батлах тухай” 2018 оны 45 дугаар тогтоолын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Согтууруулах ундааны худалдаа, үйлчилгээнд тавигдах шаардлагыг хангасан Есөнбулаг сумын Индэрт багийн Цагирагт могой ХХК-ийн Буян баян хүнсний дэлгүүрт спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийг шинээр олгосугай.

2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хууль тогтоомж, шаардлага журмыг зөрчсөн тохиолдолд зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээ авч ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Баттайван), Мэргэжлийн хяналтын газар (Г.Гантулга), Цагдаагийн газар (Д.Болдсайхан), холбогдох сумын Засаг даргад тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ГАНБАТ

